

УВС АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР



**АЙМГИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН
ГАЗАРТ ХИЙСЭН ТӨЛӨВЛӨГӨӨТ ХЯНАЛТ
ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ**

УЛААНГОМ 2025 ОН

УВС АЙМГИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН САНХҮҮГИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНД САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙСЭН ТЭМДЭГЛЭЛ

2025.05.07

Улаангом

Нэг. Нийтлэг зүйл

Аймгийн дотоод аудитын хорооны 2025 оны 01 дүгээр тогтоолоор баталсан Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсанаар дотоод аудитын хорооны даргын баталсан удирдамжаар 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдрөөс ажлын 10 хоногийн хугацаанд Биеийн тамир, спортын газрын 2024 оны санхүүгийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт хяналт шалгалтыг санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч П.Мөнхсоёлтэйгээний тамир спортын газар

Шалгалтанд хамрагдсан асуудал: НАЛТ ШАГРАЛ

- Санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр болон түүнийг үндэслэн гаргасан заавар, журам, дүрмийн хэрэгжилтийн байдал
- Өр авлагын барагдуулалт, ууссан өр авлагыг данс бүртгэлд тусгасан эсэх
- Эмнэ хийгдсэн шалгалауд, төлбөр зөрчил, түүний барагдуулалт
- Иргэн аж ахуйн нэгжтэй байгуулсан гэрээ, түүний хэрэгжилт
- Төсвийн тухай хууль болон холбогдох журмууд хэрхэн хэрэгжиж байгаа байдалтай танилцаж тулгарч буй асуудлыг дүгнэх, эрсдлээс урьдчилан сэргийлэх, илэрсэн зөрчил дутагдлыг засаж запруулах арга хэмжээний санал боловсруулах

Шалгалтанд хамрагдсан байгууллагын талаарх товч мэдээлэл:

- Аймгийн Биеийн тамир, спортын газар нь 2024 онд батлагдсан орон тоо 23 байна. Үнднээс газрын дарга 1, биеийн тамирын хэлтсийн дарга 1, спортын хэлтсийн дарга 1, төрөнхийн нягтлан бодогч 1, тогтоол шийдвэр, тайлан мэдээ хүний хариуцсан ахпах мэргэжилтэн 1, албан хэрэг хөтлөлт, архив хариуцсан ажилтан 1, хяналт шинжилгээ, үүнэлгээ, дотоод асуудал хариуцсан мэргэжилтэн 1, мэдээллийн цахим сан, статистик хариуцсан мэргэжилтэн 1, нярав, заал зохион байгуулалт хариуцсан ажилтан 1, харуул 5, үйлчлэгч 3, бие бялдрын сорил, чийрэгжүүлэлт, ёвлийн спорт хариуцсан арга зүйч 1, хүүхэд, ахмад, хөгжлийн бэрхшээлтэй хүний биеийн тамирын асуудал хариуцсан арга зүйч 1, албан байгууллага, аж ахуйн нэгж, сумдын биеийн тамирын бодлого хэрэгжилт, арга зүйчийн асуудал хариуцсан арга зүйч 1, спортын тэмцээн наадам, шагнал урамшуулалт, үндэсний болон бөхийн спорт хариуцсан дасгалжуулагч 1, ёсвэрийн шигшээ баг, хүүхдийн спорт, багийн болон хэмжигдэхүүнтэй спортын төрөл хариуцсан дасгалжуулагч 1, спортын холбоод, цол зэрэг, оюуны болон хөгжиж буй спортын төрөл хариуцсан дасгалжуулагч 1 гэх орон тоо байна. Гүйцэтгэлээр 21 орон тоотой ажилласан байна.

Шалгалтад хамрагдсан хугацаанд 1-р гарын үсгийг Х.Баяртуул, 2-р гарын үсгийг нягтлан бодогч Б.Пүрэвсүрэн нар зурж төсвийн хөрөнгийг захиран зарцуулж байсан.

Шалгалтын явцад 2024 оны А, Б тушаал, хөдөлмөрийн дотоод журам, харилцах, өглөг, авлагын тооцоо, байгууллагуудад төлөх тогтмол зардлын тооцоо, бусад байгууллагатай хийсэн гэрээ, тэдгээрийн биелэлт, эд хөрөнгийн

тооллогын баримт, нярав эд хариуцагчдын тайлан, агуулахын бүртгэл, цалин хөлс олголт, нийгмийн даатгалын тайлан, татварын тайлан, санхүүгийн тайлан зэрэгт хяналт шалгалт явууллаа.

Өмнөх шалгалтаар:

- Спорт заал ашиглах гэрээ дутуу санхүүгийн баримтанд хавсаргаагүй.
- Фитнесийн танхимын түрээсийн орлогыг дансанд бүрэн төвлөрүүлээгүй.
- Биеийн тамир спортыг хөгжүүлэх хөтөлбөр, боловсролын дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллаагүй.
- Хөрөнгийг орлогод дутуу авсан.
- УАЗ-220692-033 маркийн 3799 УВА улсын дугаартай автомашины бүх эд анги тоногдсон, арал моторын дугаар өөрчлөгдсөн.
- Зарлагдаагүй тендерийн санхүүжилт 28000000 төгрөгийг биеийн тамир спортын газрын дансанд шилжүүлсэн.
- Худалдах, худалдан авах гэрээний дагуу тоног төхөөрөмж нийлүүлэгдээгүй. Өмнөх шалгалтаар илэрсэн эдгээр 7 зөрчил давтагдаагүй.

Хоёр. Төсвийн хөрөнгийн зарцуулалтын байдал

Төсвийн санхүүжилт, үндсэн үйл ажиллагааны орлогын зүйл ангийг үзвэл: Аймгийн Биеийн тамир, спортын газар нь 2024 онд улсын төсвөөс 759,145.3 мянган төгрөгийн санхүүжилт авсан. Орон нутгийн төсвөөс 497,995.1 мянган төгрөгийн санхүүжилт авсан. Засаг даргын нөөц хөрөнгө, үйл ажиллагааны орлогоос нийт 64,594.35 мянган төгрөгийн санхүүжилт авч нэмэлт санхүүжилтийн дансанд тусгаж үйл ажиллагаагаа явуулсан байна. Үүнээс үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 45,217.05 мянган төгрөг байна.

Төсвийн зарлагын зүйл ангийг авч үзвэл: цалин хөлс болон нэмэгдэл урамшилд 495,858.7 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх НДШ-д 62,021.7 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 481,494.9 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардалд 15,263.9 мянган төгрөг, дотоод албан томилолтын зардалд 8,118.2 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 26,983.7 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 15,498.5 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд нийт 147,522.5 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлэг 35,886.1 мянган төгрөг, хөрөнгө худалдан авсан зардал 9,928.9 мянган төгрөг, тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардалд 17,732.1 мянган төгрөг, хөдөө орон нутагт тогтвортой ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэгийн зардалд 8,037.97 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж шагнал урамшууллын зардалд 10,116.0 мянган төгрөг, улсын төсвийн санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг 23,096.02 мянган төгрөг, орон нутгийн төсвийн санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг 1,634.7 төгрөг байна.

Өглөг авлагын тооцоо /2024 он/

/ мянган

төгрөг/

Үзүүлэлт	2024.01.01	2024.12.31	Зөрүү	
			Өссөн	Буурсан

Өглөг	39,352.4	54,768.0	+	
Авлага	-	-		

Биеийн тамир, спортын газар өр төлбөр дансны үлдэгдэл 54,768.0 мянган төгрөг болж 15,415.6 мянган төгрөгөөр өссөн нь халаалтын төлбөрийн өглөг өссентэй холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэлгүй байна.

Гурав. Санхүү бүртгэлийн ажлын талаар:

Аймгийн Биеийн тамир, спортын газар нь 2024 оны санхүүгийн аудитаар өөрчлөлтгүй дүгнэлт авсан байна.

Шилэн дансны хуулийн хэрэгжилт: 2024 оны шилэн дансны мэдээллийг хугацаандаа оруулбал зохих 159 мэдээллээс 156 мэдээлэл хугацаандаа байршуулсан, хугацаа хоцорсон 3 мэдээлэл байна.

Худалдан авах ажиллагааны талаар: Тус газар нь 2024 онд цахим худалдан авах ажил зохион байгуулаагүй байна.

Төсвийн хөрөнгийг зарцуулахад гарсан зөрчил дутагдлын талаар:

1. Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 347 тоот тушаалын хавсралт "Ажилчин албан хаагчдын хэрэглэж байгаа эд хөрөнгийн ашиглалтын бүртгэл" маягтад тухайн эд хөрөнгийн чанар бичээгүй, тооллогын комисс гарын үсэг дутуу.

2. Байгууллагатай гэрээ байгуулахдаа 2 спорт заал түрээсэлж байсан ч аль заал гэдгийг гэрээндээ тодорхой бичдэггүй.

3. 9597УВХ улсын дугаартай тээврийн хэрэгслийн "Автотээврийн хэрэгслийн ашиглалтын хувийн хэрэг"-т хетлөлт бүрэн хийгдээгүй, 6119УВА улсын дугаартай тээврийн хэрэгсэлд "Автотээврийн хэрэгслийн ашиглалтын хувийн хэрэг" байхгүй.

4. 2024 оны 02 дугаар сарын 06-ны 02-31-01/098/06-тоот аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын улсын ахлах байцаагчийн дүгнэлтэд "Барилгын доторх даацын бус хамар ханануудад суурин суултаас шалтгаалан босоо болон ташуу ан цавууд үүссэн" гэх дүгнэлт гарсан боловч урсгал засвар хийгдээгүй, эд хөрөнгийн ашиглалт хангалтгүй байна.

Дөрөв. Төсвийн хөрөнгийн зарцуулалтад өгсөн зөвлөмж:

1. Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 347 тоот тушаалын хавсралт "Ажилчин албан хаагчдын хэрэглэж байгаа эд хөрөнгийн ашиглалтын бүртгэл" маятыг бүрэн бүрдүүлэх.

2. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хулээж авсан ажилтан хариуцна." гэх заалтыг мөрдөж, заал түрээслэх гэрээндээ түрээсэлж буй заалны нэр хаягийг нь тодорхой бичиж гэрээ байгуулдаг байх.

3. Зам тээврийн хөгжлийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/199 дүгээр тушаалын 4 дүгээр зүйлийн 4.4.1-д "Баримт бичгийн бүрдлийг

хангасан байх" гэж заасны дагуу автотээврийн хэрэгсэл тус бүрийн бичиг баримтын бурдлийг хангаж, автотээврийн хэрэгслийн хувийн хэргийг хөтлөх.

4. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-д "Төрийн өмчтэй хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна" гэх заалтыг мөрдөж ажиллах.

Тав. Шалгуулагч этгээдийн санал, хүсэлт:

*Спортигын ордоны их дэсварчны халбартай агуулсан
тихийн бүрч чуслын бий цдаагийн дундажт гарчирхлыг
их дэсварчны зурагаа тохижуулж додж, 2024, 2025 оны
аарвалыг орнуулж ийн их дэсварчны агуулсан санал
хүрч чуулж байж таа боловсруулж саналтуулж иштэй*

шийдвэр дэх чуй байна

ТЭМДЭГЛЭЛ

БИЧСЭН:
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ

Т. Монгол П.МӨНХСОЁЛ

ХЯНАСАН:
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ

Д. Чойжилсүрэн



ТАНИЛЦСАН:

АЙМГИЙН БИЕИЙН ТАМИР СПОРТЫН
ГАЗРЫН ДАРГЫН УҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ *Х.Баяртуул* Х.БАЯРТУУЛ

НЯГЛАН БОДОГЧ

А. Аюун Б.ПУРЭВСҮРЭН